



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2019 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

**Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар,  
Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд  
хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын дүнг хэлэлцсэн тухай**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх тухай” А-175 дугаар тушаалын хүрээнд Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын 2018 он, 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тайлан, дүгнэлттэй танилцав.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын үр дүнгээр холбогдох байгууллагуудад өгөх зөвлөмжийг нэгээс тавдугаар хавсралтаар баталсугай.

2. Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, сумдын Хүнс, хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасгийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, хамртан ажиллахыг Завхан аймгийн Засаг дарга /С.Батсайхан/-д зөвлөсүгэй.

3. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газар /Д.Түмэндэмбэрэл/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар /М.Энх-Амар/, Санхүү хөрөнгө оруулалтын газар /Б.Цогбадрах/, Мал аж ахуйн хөгжлийн бодлого зохицуулалтын газар /Д.Батмөнх/, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс / Д.Бадруун/, Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /Н.Батбаяр/, Завхан аймгийн Мал эмнэлгийн газар /Д.Баясгалан/-т тус тус үүрэг болгосугай.

4. Зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Мал эмнэлгийн ерөнхий газар /Д.Түмэндэмбэрэл/, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар /М.Энх-Амар/, Санхүү хөрөнгө оруулалтын газар /Б.Цогбадрах/, Мал аж ахуйн хөгжлийн бодлого зохицуулалтын газар /Д.Батмөнх/, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс / Д.Бадруун/, Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /Н.Батбаяр/, Завхан аймгийн Мал эмнэлгийн газар /Д.Баясгалан/-г тус тус даалгасугай.

5. Зөвлөмжийн хэрэгжилтийг хяналтад авч, дотоод аудитын хорооны хурлаар хагас, бүтэн жилээр хэлэлцүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Ч.Тавинжил/-д үүрэг болгосугай.

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, ДОТООД  
АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА** **Ч.УЛААН**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

## **ЗАВХАН АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР, МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх тухай” А-175 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### **НЭГДСЭН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР**

1. Цөм сүргийн үржлийн төв нэг орон тоогоор ажиллаж байгаа нь үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа тул Цөм сүргийн бүтэц, зохион байгуулалт, харьяаллыг судлан үзэж, шийдвэрлэх,
2. Сумын Хөдөө аж ахуй болон Мал эмнэлгийн тасгийн орон тооны мэргэжилтний цалинг ТЗ-3 ангиллын хүрээнд тогтоосон асуудлыг судлаж, хууль, журмын хүрээнд шинэчлэн тогтоох
3. Жижиг, дунд үйлдвэрлэлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгож, зээлийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгийн захиран зарцуулалт, төсөл хэрэгжүүлэлт, эргэн төлөлт, тайлагналттай холбоотой харилцаа, төрийн захиргаа болон нутгийн захиргааны байгууллагууд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, төслийн хэрэгжилт, хяналт тавих, үр дүнг үнэлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох

### **САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАРТ**

1. Хөрөнгө оруулалт, худалдан авалтын гэрээт ажлын санхүүжилт олгох, гэрээ дүгнэсэн актын үндэслэлийг шалгахдаа орон нутгаас ирүүлж буй анхан шатны баримт, гүйцэтгэгч байгууллагын баримтыг үндэслэж үлдэгдэл санхүүжилтийг шилжүүлж байх,

### **МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ**

1. ХХААХҮ-ийн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулж байгаа болон аймгийн Засаг даргатай байгуулж байгаа бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгагдах Мал аж ахуйн талаар хэрэгжүүлэх арга хэмжээний санал, төслийг ХХААГ-т хүргүүлж, санал авах, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд арга хэмжээний зардал, хөрөнгө оруулалтыг тусгах боломжийг бүрдүүлж ажиллах,
2. Малын үзлэг, ангилалтын ажлыг “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, “Монгол мал” хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хангаж, холбогдох хуулийн хүрээнд хэрэгжүүлж ажиллах
3. Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээний санхүүжилтийг технологийн хугацаанаас өмнө орон нутагт олгох, ажлыг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх,
4. 2018 онд тараагдсан мал угаалын ванны үлдэгдэл (225 ширхэг)-ийг орон нутагт нийлүүлэх ажлыг яаралтай зохион байгуулах,

## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ

1. Төрийн албан хаагчдын ХШҮ, тайлагналттай холбоотой арга зүйн удирдлагаар хангаж ажиллах

### ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭСТ:

1. Хөдөө орон нутгийн мэргэжилтнүүдийг гадаад улсын туршлага судлах арга хэмжээнд хамруулах, төсөл, хөтөлбөрийн хүрээнд орон нутагт сургалт зохион байгуулах, оролцоог хангахад анхаарч ажиллах,

2. Гадаадын төслүүд болон салбарт хэрэгжиж байгаа сангуудын хөрөнгө оруулалтын асуудалд орон нутгийн төрийн байгууллагуудын оролцоо хангалтгүй байна. Иймд гадаадын төсөл хөтөлбөрөөс орон нутагт хэрэгжүүлж байгаа ажлуудад орон нутгийн байгууллага, санхүүжүүлэгч, ашиг хүртэгч нарын хооронд гурвалсан гэрээ байгуулж, тус бүрийн үүрэг, хариуцлагыг тодорхойлон ажиллаж хэвшүүлэх,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

## **ЗАВХАН АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх тухай” А-175 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Завхан аймгийн Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### **МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ**

1. Аймгийн мал эмнэлгийн газрын даргын сонгон шалгаруулалтыг зарлах, албажуулах,
2. Аймгийн ХХААГ болон Мал эмнэлгийн газрын хөрөнгө хуваарилах тогтоолыг яаралтай албажуулах талаар ТӨБХЗГ-тай хамтран ажиллах,
3. Сумын ХХААТ, МЭТ-ийн хөрөнгө хуваарилах ажлыг хэрэгжүүлэх,
4. Аймгийн Мал эмнэлгийн газрын ажлын байрны асуудлыг яаралтай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх,
5. Мал эмнэлгийн газраас сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн нэгжид олгож байгаа вакцин эм, биобэлдмэл болон бусад материалыг дагалдах падаангүй хүлээлцэх, нөхөж падаан баримтыг олгох явдал байсаар байгаа тул яаралтай залруулах,
6. Аймгийн хэмжээнд 5 суманд зөвхөн нэг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж ажиллаж, тэдгээрт 43,880.0-132,478,0 толгой мал оногдож байгаа нь стандартаас өндөр үзүүлэлт тул мал эмнэлгийн нэгж байгуулахад бодлогын дэмжлэг гаргах,
7. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт хангах хүрээнд боловсруулж байгаа аймгийн мал эмнэлгийн газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт дахь ажлын давхардал, хийдлийг арилгаж, эцэслэн баталгаажуулах,
8. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэгт заасан “Гурвалсан гэрээний загвар”-ыг хуульд нийцүүлэн шинэчлэн батлах, аймаг, сумын төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхой тусгаж өгөх,
9. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах, хяналтын оновчтой механизм, мэдээллийг цаг тухай бүр авах тогтолцоо бүрдүүлэх, орон нутгийн үйлчилгээний хөлс олгох үйл ажиллагаанд тавих хяналтын арга зүйгээр хангах,
10. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тархвар зүйн нөхцөл байдалд үндэслэн хэрэгжүүлэх арга зүйн сургалт, сурталчилгааг сайжруулах, мэргэжилтэн, малын эмч нарын мал, амьтны өвчний талаарх тархвар зүйн ойлголтыг сайжруулах,
11. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын болон холбогдох алба, нэгжийн стратеги төлөвлөгөөг батлуулах, мөрдүүлэх,
12. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг дагалдан гарсан дүрэм, журам, зааврыг мал эмнэлгийн газар болон тасаг, нэгжийн мэргэжилтнүүдэд судлуулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах, гарын авлага, эмхэтгэл хэвлүүлэн тараах,
13. Мал эмнэлгийн газрын баримт бичгийн стандарт, бүрдүүлэлтэд тавигдах шаардлага мөрдөгдөхгүй байгаа тул албан бичгийн стандарт, арга зүйн сургалтыг холбогдох мэргэжилтнүүдэд зохион байгуулах,

14. Орон нутагт малын эмч нарын залуу үеийнхэн ажиллах сонирхолыг төрүүлэх боловсон хүчний бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх,

15. УМЭАЦТЛ нь мал, амьтны зарим өвчнийг оношлох, онош баталгаажуулах шинжилгээг төлбөртэй гүйцэтгэж байгаа асуудлыг судлан үзэж холбогдох хууль, тухайн байгууллагын чиг үүргийн хүрээнд шийдвэрийг яаралтай гаргаж, хэвийн ажиллагааг хангах,

16. Биокомбинат УТҮГ-аас Завхан аймгийн мал эмнэлгийн газартай байгуулсан №2019/01/11 дугаартай гэрээний дагуу нийлүүлэх вакцинаас Дуут хавдраас сэргийлэх вакцин 5000 л, Сохор доголоос сэргийлэх вакцин 5000 л тус тус нийлүүлэгдээгүй байна. Уг гэрээний 3.7-д вакцин нийлүүлэх хугацааг 2019.04.01-2019.07.15-ны хооронд гэж заасан байгаа нь мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний график хугацаатай зөрчилдөх, технологийн хугацаанд мал, амьтныг хамруулах байдалд хүндрэл үүсч болзошгүй байгаа тул гэрээний холбогдох заалтад анхаарах,

17. Орон нутгийн мал эмнэлгийн байгууллагын “бүх зүйлийг дээрээс” хандлагыг өөрчлөх, орон нутгийн мал эмнэлгийн байгууллагууд ажил санаачлан хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх,

18. МЭЕГ-ын даргын 2018.09.12-ны өдрийн “Дүрэм батлах тухай” А/21 дүгээр тушаалаар баталсан “Мал эмнэлгийн ерөнхий газрын орон нутаг дахь мал эмнэлгийн байгууллагын дүрэм” нь хууль, эрх зүйд нийцэх эсэхэд дүгнэлт хийж, шаардлагатай гэж үзвэл хуульд нийцүүлэх, шаардлагагүй гэж үзвэл хүчингүй болгох,

19. Мал эмнэлгийн лабораторийн мэргэжилтнүүдийн /нарийн мэргэшил/ тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах, өндөр өртөг бүхий лабораторийн тоног хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх,

20. Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн шинжээч, мал эмнэлгийн боловсон хүчнийг сургаж мэргэшүүлэх, мэргэжил мэдлэгийг сайжруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах,

21. Мал эмнэлгийн газрын бүтцийг дахин авч үзэх, ингэхдээ молекул биологийн шинжээч, мал эмнэлгийн газрын нэг мэргэжилтэнд хариуцуулсан олон чиглэлийн ажил үүргийг уялдаа холбооноос хамааран хариуцуулах гарцыг олох,

22. Аймаг, сум, орон нутгийн удирдлагуудад мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, дагалдан гарсан эрх зүйн баримт бичгийг сурталчлан таниулах, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалтай холбогдох мал эмнэлгийн арга хэмжээнд тэдний оролцоог хангах талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, аймгийн удирдлагуудтай шаардлагатай тохиолдолд санамж, хэлцэл байгуулах зэргээр тэдний ойлголт, хандлагыг өөрчлөх,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн  
ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын  
хорооны 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 03  
дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

## **ЗАВХАН АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР, МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх тухай” А-175 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### **ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД**

1. Сүргийн зохист харьцааг “хангайн бүсэд нийт сүрэгт хонь 50-60 хувь, ямаа 20-25 хувь, үхэр 15-20 хувь, адуу 10-15 хувь, тэмээ 5.0 орчим хувийг эзэлж байх нь тохиромжтой байдаг бол тал хээрийн бүсэд хонь 60-65 хувь, ямаа 15-20 хувь, үхэр 5-10 хувь, адуу 10-15 хувь, тэмээ 15-20 хувийг эзэлж байх нь зохимжтой” гэж Мал аж ахуй, биотехнологийн сургуулийн судлаачдын тэмдэглэснийг анхаарч, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын хэрэгжилтийг хангах байдлаар орон нутагт сүргийн зохист харьцааг зөв төлөвлөх, хэрэгжүүлэх,

2. Аймгийн хэмжээнд мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг хүлээж байгаа мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн энэ чиглэлийн үйл ажиллагаанд шаардагдах эм урвалж, цомгийг аймаг, орон нутгийн төсөвт суулгах, лабораторийн шинжилгээний чадавх нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх,

3. Сум, орон нутгийн удирдлагуудад мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, дагалдан гарсан эрх зүйн баримт бичгийг сурталчлан таниулах, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалтай холбогдох мал эмнэлгийн арга хэмжээнд тэдний оролцоог хангах талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах,

4. ХХААГ-ын албан хаагчдын ажлын байрны асуудлыг шийдвэрлэх,

5. Улс болон орон нутгаас олгож буй мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг аймгийн мал эмнэлгийн газраар дамжуулан шууд сумдын мал эмнэлгийн хувийн нэгжүүдийн дансанд шилжүүлж байх зохицуулалтыг хийх

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

## **ЗАВХАН АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР, МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх тухай” А-175 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### **ЗАВХАН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАРТ**

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаал, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын хэрэгжилтийг хангаж, үнэн зөв бөгөөд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу төлөвлөж, тайлагнах

2. ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-119 дүгээр тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын хэрэгжилтийг хангаж, орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх зорилт хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, төрийн дэмжлэг авснаар орон нутагт гарсан хөгжил дэвшил, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд, үр дүн, үр өгөөжийг тооцож ажиллах, тайлагнаж

3. Төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгийг байгууллагын данс бүртгэлд бүрэн төвлөрүүлэх, гэрээт ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах;

4. Дутуу гүйцэтгэлтэй гэрээт ажлыг хүлээж авахгүй байх, хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүн, тайлагналтад анхаарч ажиллах;

5. Өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулахдаа гэрээт ажлыг гүйцэтгэлийг дүгнэсэн, баталгаажуулсан баримтад үндэслэх;

6. Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, ашиглалтгүй хөрөнгийг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх;

7. Автомашины хувийн хэргийг бүрэн хөтлөх, шатахуун зарцуулалт, замын хуудасны тооцоог дэлгэрэнгүй хөтөлж хэвших;

8. Өөрийн орлогыг данс бүртгэлд бүрэн төвлөрүүлэх, дотоод хяналтыг сайжруулах;

9. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу цалин хөлсийг сард 2 удаа олгох;

10. Сумдын Хөдөө аж ахуйн тасгийг 3 орон тоотой ажиллуулах, ажлын байрны тодорхойлолтод зааснаас өөр мэргэжлийн албан хаагч томилсон сумдад тухайн албан тушаалын цалингийн санхүүжилтийг олгохгүй байх талаар санал боловсруулж, аймгийн Засаг даргад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

11. Сумдын Хөдөө аж ахуйн тасгийн ажлын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг тогтоох, үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг боловсруулж мөрдөх, ажлын сайн туршлагыг бусад сумдад түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

12. Бүх аймаг, сумдын малын бүртгэлжүүлэлтийн программ нь ажиллаж байгаа, ажиллахгүй эвдэрч зогссон зэрэгт бүрэн судалгаа хийж, ашиглалтад оруулах, уг программыг зориулалтын дагуу ажиллуулахад хариуцсан мэргэжилтэнд мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч, бүртгэлжүүлэлтийн ажилд чанарын ахиц гаргах;

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар тогтоолын тавдугаар хавсралт

## **ЗАВХАН АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР, МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх тухай” А-175 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### **ЗАВХАН АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАРТ:**

1. Зооноз, халдварт өвчин, тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн, Шимэгчтэх, халдваргүй өвчин, малын эм, биобэлдмэлийн хэрэглээний асуудал хариуцсан мэргэжилтэн, МЭТ, МЭҮН болон дотоод хяналт, шилжилт хөдөлгөөн, баталгаажуулалт, эмийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон Захиргаа, санхүүгийн албаны даргыг сонгон шалгаруулах, томилох,

2. Мал эмнэлгийн газраас сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн нэгжид олгож байгаа вакцин эм, биобэлдмэл болон бусад материалыг дагалдах падаангүй хүлээлцэх, нөхөж падаан баримтыг олгох явдал байсаар байгаа тул яаралтай залруулах,

3. Аймгийн хэмжээнд 5 сума тус бүрт зөвхөн нэг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж ажиллаж, тэдгээрт 43,880.0-132,478.0 толгой мал оногдож байгаа нь стандартаас өндөр үзүүлэлт тул мал эмнэлгийн нэгж байгуулах асуудлыг бодлогоор дэмжих,

4. Мал эмнэлгийн тасагтай гүйцэтгэлийн гэрээ, Сумын Засаг дарга, Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн хооронд Гурвалсан гэрээ байгуулж ажиллах, гэрээг жил бүрийн эцэст дүгнэх,

5. Мал эмнэлгийн газрын даргын батлан мөрдүүлж байгаа “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталж, хэрэгжилт хангах, Хөдөлмөрийн тухай хуульд “Хөдөлмөрийн дотоод журам”-аар зохицуулахаар тусгасан харилцааг бүрэн тусгах, хуулиас давсан зохицуулалтыг хасах, лабораторийн ажилтны хортой нөхцөл, хорогдуулсан цаг зэргийг тусгах,

6. 2018 онд ХХААХҮЯ-наас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Завхан аймагт хуваарилагдсан 14 ширхэг Мал угаалгын зөөврийн тоног төхөөрөмжөөс 8 ширхэгийг “Тэгш агьт” ХХК-иас хүлээн аваагүй байгаа сумдад мэдээллийг хүргүүлж, татан авах ажлыг зохион байгуулан, хөрөнгийн бүртгэл зэргийг хийлгэх, ашиглалт хангах,

7. Төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгийг байгууллагын данс бүртгэлд бүрэн төвлөрүүлэх, гэрээт ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах;

8. Дутуу гүйцэтгэлтэй гэрээт ажлыг хүлээж авахгүй байх, хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүн, тайлагналтад анхаарч ажиллах;

9. Өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулахдаа гэрээт ажлыг гүйцэтгэлийг дүгнэсэн, баталгаажуулсан баримтад үндэслэх;

10. Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, ашиглалтгүй хөрөнгийг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх;

11. Автомашин хувийн хэргийг бүрэн хөтлөх, шатахуун зарцуулалт, замын хуудасны тооцоог дэлгэрэнгүй хөтөлж хэвших;



12. Өөрийн орлогыг данс бүртгэлд бүрэн төвлөрүүлэх, дотоод хяналтыг сайжруулах;

13. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу цалин хөлсийг сард 2 удаа олгох;

14. Мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг ажлын гүйцэтгэл, үр дүн, холбогдох анхан шатны баримтад үндэслэн шилжүүлж байх;

15. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг дагалдан гарсан дүрэм, журам, зааврыг мал эмнэлгийн газар болон тасаг, нэгжийн мэргэжилтнүүдэд судлуулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах,

16. Мал эмнэлгийн газрын баримт бичгийн стандарт, бүрдүүлэлтэд тавигдах шаардлага мөрдөгдөхгүй байгаа тул албан бичгийн стандарт, арга зүйн сургалтыг холбогдох мэргэжилтнүүдэд зохион байгуулах,

17. Орон нутагт малын эмч нарын залуу үеийнхэн ажиллах сонирхолыг төрүүлэх боловсон хүчний бодлого, дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

18. Мал, амьтны өвчний тархвар зүйн нөхцөл байдал, эрсдэлийн дүн шинжилгээнд суурилан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, өвчингүй, тайван байдлыг нотлох арга хэмжээг хэрэгжүүлэх;

19. Мал эмнэлгийн вакцины захиалгын үндсэн дээр сумдад тараахдаа зарлагын баримтыг заавал хөтөлж, хүлээж авсан, хүлээлгэж өгсөн тэмдэглэл, вакцины цуврал дугаарыг тодорхой бичүүлж байх: